



АУДИТЫН КОД: САГ-2018/06/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn

Ахлах аудитор Р.Цолмон

Утас: 260512 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn

Аудитор Б.Баярмаа

Утас: 261740 Цахим хаяг: bayarmaab@audit.gov.mn

Гэрээт аудитор Д.Мөнхдэлгэр

Утас: 261740

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ.....	2
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ.....	4
3	АУДИТЫН ТАЙЛАН.....	6
3.1	Оршил.....	6
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	6
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	7
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
3.5	Дотоод аудит.....	8
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	10
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	10
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	11
3.9.1	ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХЭД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ.....	11
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	11
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	12
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	12
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	13
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3.16	Үр өгөөжийн тооцоолол.....	13
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	13
4.1	Давсан орлогын зарцуулалтын талаар.....	15
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	16
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	16
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	17
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
6	АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ.....	21

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн
2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1042
танай _____ -ны № _____ -т

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА С.ДАВААСҮРЭН
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG32.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Оршил

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Санхүүгийн зохицуулах хорооны санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй гэж үзсэн авлага, урамшууллын талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 6-наас 2018 оны 4 дүгээр сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, аудитор Б.Баярмаа, гэрээт аудитор Д.Мөнхдэлгэр нар хариуцаж хэрэгжүүлэв.



Санхүүгийн зохицуулах хорооны дарга 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 3/1587 дугаар албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Санхүүгийн зохицуулах хорооны эрхэм зорилгыг “Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлэх” гэж тодорхойлжээ.

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага бөгөөд анх банкнаас бусад санхүүгийн салбарыг хариуцах чиг үүрэгтэй хуульчлагдаж, үнэт цаас, даатгалын салбар, бичил санхүүгийн салбарын зохицуулалт хамрагдаж байсан. Гэвч шинэ тутам үүсэн бий болж буй зах зээлийн харилцаанаас шалтгаалан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаа, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан даатгалын үйл ажиллагаа, Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа зэрэг зохицуулалтын үйл ажиллагаанууд хамрагдах болсон байна.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Санхүүгийн зохицуулах хороо тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг 3 үзүүлэлтээр баталгаажуулсныг дараах гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна. Үүнд:


- ✓ Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр шинээр боловсруулах журмын төсөл 6 байхаар төлөвлөж, 10 журам, заавар, маягт боловсруулж баталсан;
- ✓ Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг 43 аж ахуйн нэгж, байгууллагад хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 243 байгууллагад хяналт хэрэгжүүлсэн;
- ✓ Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх 1 хөтөлбөр боловсруулахаар төлөвлөж, биелэлт 100 хувьтай тус тус гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүйгээс үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.



Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 22 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Санхүүгийн зохицуулах хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу боловсруулсан боловч эцэслэж батлаагүй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн санхүүгийн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.


Санхүүгийн зохицуулах хорооны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Санхүүгийн зохицуулах хорооны Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэд Дотоод хяналтын хэлтэстэй бөгөөд хорооны үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Тайлант онд дотоод хяналтын хэлтсээс авч хэрэгжүүлсэн ажлаас дурьдвал:

- ✓ Улсын байцаагчдын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- ✓ Хорооны хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, өгсөн үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;
- ✓ "Дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт"-д ХШҮ хийх;
- ✓ Ажлын албаны зарим нэгжүүдийн гүйцэтгэх чиг үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, эрсдэлийг тооцох;
- ✓ Хорооны дарга болон Ажлын албаны даргын тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- ✓ 2016 оны хүлээгдэж байгаа болон 2017 оны хариутай гомдлын шийдвэрлэлтэд аудит хийх;



Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн
2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

- ✓ Ажлын албаны болон газруудын /сонгож орох/ 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- ✓ Ажлын албаны ажлын цагийн ирц, ашиглалт, чөлөө олголт, өвчлөлтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- ✓ Хорооны үйл ажиллагааны эрсдэлийг хянах, тогтоох, сэргийлэх талаар баримтлах заавар, зөвлөмж, гарын авлага боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- ✓ Хорооны үйл ажиллагааны эрсдэлийн талаар судалгаа хийж, учирч болзошгүй эрсдэлийг тогтоон, үнэлэлт дүгнэлт өгч, эрсдэлийг хянах, тогтоох, сэргийлэх талаар баримтлах заавар, зөвлөмж, гарын авлага боловсруулах зэрэг үйл ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

Хүснэгт№1

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	18	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	32	
3	Шалгалтад хамрагдсан нэгжийн тоо	АА-ны бүх газар хэлтэс	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	60
		Дүн (сая.төг)	40.6
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	43
		Дүн (сая.төг)	40.6
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	3
		Дүн (сая.төг)	-

Эх сурвалж: Дотоод хяналтын хэлтсийн үйл ажиллагааны тайлан

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 2017 оны төсвийн орлого бүрдүүлэлт, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалтад хяналт, шалгалт тус тус хийж гүйцэтгэсэн байна Шалгалтаар нийт 7 зөрчил дутагдал илэрсэн бөгөөд нийт 22 зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг 89 хувьтай гэж үнэлсэн байна.


Энэ нь дотоод аудитын ажлын үр дүн бөгөөд системийн хэмжээгээр эрсдэл “бага”, дотоод хяналт үр нөлөөтэйг харуулж байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх 3 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Санхүүгийн зохицуулах хорооны Төсвийн ерөнхийлөн захирагчийн орлогыг хэмжээг 822.4 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 1,916.8 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого олж, орлогын төлөвлөгөөг 1,094.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 2,514.7 сая төгрөг байхаар баталж, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 67 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгох шийдвэрийн дагуу 42.3 сая төгрөгийг олгож, нийт 2,557.0 сая төгрөгийг зарцуулахаар



Төсвийн зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 99.2 хувьтай буюу 20.4 сая төгрөг хэмнэгдсэн байна. Төлөвлөсөн зардлыг ерөнхий ангиллаар хэтрүүлэн зарцуулаагүй боловч зарим зардлыг хэтрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу гаргаж ирүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг энэ тайлангийн 5.5-д дэлгэрэнгүй харуулав.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Санхүүгийн зохицуулах хорооны Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу мэдээлсэн байна. Тухайлбал:

- ✓ “Төсөв” цэсний Дараа жилийн төсвийн төсөл, улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэл, санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг тус тус 1 удаа;
- ✓ “Төсөв” цэсний Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, Цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээг тус тус 12 удаа;
- ✓ “Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт” цэсэнд Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүй тул хамааралтай мэдээлэл байхгүй;
- ✓ “Бусад” цэсний Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл...төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт хорооны даргын хөрөнгөтэй холбоотой захирамжийг сар бүр мэдээлж ажилласан байна.

Санхүүгийн зохицуулах хороо 2017 онд шилэн дансны цахим хуудаст нийт 149 мэдээллийг тус тус байршуулан ажилласан байна.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.


Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Санхүүгийн зохицуулах хороотой холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 чиглэлд эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 22 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.



3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХЭД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвөөс санхүүжиж, тайлан нэгтгэдэг харьяа байгууллага байхгүй болно.

3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 630.4 сая төгрөгийн алдааг залруулж, нийт 45.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийн 3.3 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 4.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 37.9 сая төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар 1 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.9.2.1 Орлогын талаар

Сангийн сайдын 2017 оны 2017 оны 342 дугаар тушаалаар давсан орлогоос буцаан олгосон 630.4 сая төгрөгийн орлогыг мөнгөн гүйлгээний тайланд илүү бүртгэж тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг Сангийн сайдын холбогдох журмын дагуу бэлтгээгүй.

Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

3.9.2.2 Авлагын талаар

2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлстэст НДШ-ийн илүү төлөлт хийж 3.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.9.2.3 Худалдан авалтын талаар


Холбогдох шийдвэргүй, гэрээ байгуулаагүй ажлын байрны засвар хийлгэхээр "Хитрөү" ХХК-д 4.3 сая төгрөгийн урьдчилгааг шилжүүлж, засварын ажлыг гүйцэтгээгүй байна.

Төсвийн хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.9.2.4 Давсан орлогын зарцуулалтын талаар

Тайлант онд давсан орлогоос тодорхой шалгуургүйгээр 23 ажилтанд 37.9 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон байна.



Энэ нь Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-т "Менежер нь гэрээний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээг үндэслэн Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг тус тус баримтлан эрх хэмжээнийхээ хүрээнд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар эрх бүхий этгээдэд саналаа тавьж болно" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, урамшууллыг ажлын үр дүн, шалгуурт үндэслэн олгож байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэлтэй холбоотой дараах асуудлуудыг онцгойлон авч үзлээ. Тухайлбал:

- ✓ Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар үйл ажиллагааны орлого 822.4 сая төгрөг байхаар баталснаас 1,916.8 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн байна. Үүнээс 114.3 сая төгрөгийн урьд оны зохицуулалт үйлчилгээний хөлс төлөгдсөн бөгөөд тайлант онд 21.6 сая төгрөгийн орлогыг төлүүлж, бүрдүүлээгүй байна.
- ✓ Тус хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т "санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэж заасныг үндэслэн Даатгалын чиглэлээр 6, Үнэт цаасны чиглэлээр 1 удаагийн сургалт зохион байгуулж нийт 508 хүнийг сургалцуулж, 61.5 сая төгрөгийн сургалтын төлбөрийн орлого олсон боловч сургалтын төлбөрийн тогтоосон журам боловсруулж, мөрдөөгүй байна.
- ✓ Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 261 дүгээр тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны бүтэц, орон тоог 144 хүний орон тоотой байхаар баталж, тайлант онд 144 хүн ажилласан бөгөөд 2017 онд 236 тушаал шийдвэр гарснаас албан тушаалд шинээр томилогдсон 26, ажлаас чөлөөлсөн 21 албан тушаал гарсан байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд


Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар гүйцэтгэлийг үзэх боломжгүй дараах асуудлууд байна.

- ✓ Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 36 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн биржийн зуучлагч, брокеруудаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний өмнөх онуудын үлдэгдэл 361.9 сая төгрөгийг 2018 оны 8 дугаар сард багтаан төвлөрүүлэх шийдвэрийн хэрэгжилт,
- ✓ Тус хорооны дэргэдэх ахмадын сангийн дансанд улсын төсвийн давсан орлогоос ахмадуудад нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор шийдвэрлэж, тус дансанд шилжүүлэн 18.8 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Иймд дээрх асуудлыг 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийх завсрын аудитаар үзэх шаардлагатай гэж үзлээ.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 630.4 сая төгрөгийн алдааг залруулж, нийт 45.5 сая



төгрөгийн алдаа, зөрчлийн 3.3 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 4.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 37.9 сая төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар 1 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгснийг биелүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 11 дүгээр сарын 30-ны 1/3512 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 3,778.5 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь 75.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.9-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.


Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дугаар хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 7.6 сая төгрөгийн үр өгөөжийн тооцоолол хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.

4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зөрчлийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд Санхүүгийн хяналтын сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.



Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

**4.1 Давсан орлогын зарцуулалтын
талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд давсан орлогоос тодорхой шалгуургүйгээр 23 ажилтанд 37.9 сая төгрөг олгосон нь Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-т "Менежер нь гэрээний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээг үндэслэн Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг тус тус баримтлан эрх хэмжээнийхээ хүрээнд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар эрх бүхий этгээдэд саналаа тавьж болно" гэснийг мөрдөөгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

- Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, ажилтнуудад урамшуулал олгохдоо ажлын үр дүн, гүйцэтгэлийн дүгнэлтийг үндэслэн олгож байх;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Холбогдох хууль, эрх зүйн акт заавар журмыг мөрдөөгүй байх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	49,343.5	298,131.2
МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,882.8	18,851.0
АВЛАГА	7,818.3	250,344.9
УРЬДЧИЛГАА	0.0	6,020.7
БАРАА МАТЕРИАЛ	34,642.4	22,914.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	742,423.4	356,778.5
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	742,423.4	356,778.5
Биет хөрөнгө	522,356.5	237,230.0
Биет бус хөрөнгө	220,066.9	119,548.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	791,766.9	654,909.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,930.0	3,806.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,930.0	3,806.4
Өглөг	1,930.0	3,806.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	789,836.9	651,103.3
Засгийн газрын хувь оролцоо	789,836.9	651,103.3
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	569,052.4	569,052.4
Хуримтлагдсан үр дүн	131,247.3	82,050.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,537.1	0.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	791,766.9	654,909.7

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,155,297.5	3,797,328.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,419,408.2	1,923,867.2
Нийтлэг татварын бус орлого	1,228,340.5	1,923,867.2
Тусламжийн орлого	191,067.7	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,735,889.2	1,873,461.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,513,284.6	3,784,426.9
УРСГАЛ ЗАРДАЛ	3,513,284.6	3,784,426.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,870,048.5	2,598,921.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,639,663.3	1,621,988.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,803.8	195,943.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,417.6	176,571.3
Хангамж, бараа материалын зардал	113,810.1	101,586.1
Нормативт зардал	0.0	2,137.5
Эд хогшил, урсгал засварын зардал	5,116.6	3,287.7
Томилолт, зочны зардал	92,985.9	102,383.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	271,561.9	152,860.3
Бараа үйлчилгээний бусад зардал	358,689.3	242,162.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	643,236.0	1,185,505.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-357,987.1	12,901.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,560.0	151,634.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-371,547.1	-138,733.6

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,161,384.0	0.0	1,161,384.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,161,384.0	0.0	1,161,384.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-371,547.1	0.0	-371,547.1
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	789,836.9	0.0	789,836.9
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	789,836.9	0.0	789,836.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	89,537.1	0.0	89,537.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	879,374.0	0.0	879,374.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-89,537.1	0.0	-89,537.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-138,733.6	0.0	-138,733.6
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	651,103.3	0.0	651,103.3

5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	7,189,206.8	3,960,281.3
ТАТВАРЫН ОРЛОГО	57,133.5	44,978.0
Бусад татвар, төлбөр, хураамж	57,133.5	44,978.0
Бусад нийтлэг төлбөр, хураамж	57,133.5	44,978.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,310,958.9	1,388,900.3
Нийтлэг татварын бус орлого	5,138,309.1	1,388,900.3
Тусламжийн орлого	172,649.9	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,821,114.4	2,526,403.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,494,939.3	3,948,313.1
УРСГАЛ ЗАРДАЛ	7,494,939.3	3,948,313.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,603,336.5	2,614,455.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,638,742.6	1,622,069.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,802.1	198,600.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,717.6	176,571.3
Хангамж, бараа материалын зардал	69,268.9	82,767.6
Нормативт зардал	0.0	2,175.0
Эд хогшил, урсгал засварын зардал	5,934.5	251,760.3
Томилот, зочны зардал	78,268.3	123,944.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	177,549.2	155,652.5
Бараа үйлчилгээний бусад зардал	258,053.4	914.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,891,602.8	1,333,857.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-305,732.5	11,968.2
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-305,732.5	11,968.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	312,615.3	6,882.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,882.8	18,851.0

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн
2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,557,001.2	2,536,571.2	20,430.0	99.2
УРСГАЛ ЗАРДАЛ	2,557,001.2	2,536,571.2	20,430.0	99.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,184,869.9	2,183,790.2	1,079.7	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,603,800.3	1,603,156.4	643.9	100.0
Үндсэн цалин	1,385,593.5	1,263,265.8	122,327.7	91.2
Нэмэгдэл	134,018.4	144,725.7	-10,707.3	108.0
Унаа хоолны хөнгөлөлт	84,188.4	195,164.9	-110,976.5	231.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	176,418.0	176,418.0	0.0	100.0
Тэтгэврийн даатгал	112,266.0	112,266.0	0.0	100.0
Тэтгэмжийн даатгал	16,038.0	16,038.0	0.0	100.0
ҮОМШӨ-ний даатгал	12,830.4	12,830.4	0.0	100.0
Ажилгүйдлийн даатгал	3,207.6	3,207.6	0.0	100.0
Эрүүл мэндийн даатгал	32,076.0	32,076.0	0.0	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,280.0	170,280.0	0.0	100.0
Байрны түрээс	170,280.0	170,280.0	0.0	100.0
Хангамж, бараа материалын зардал	71,840.0	71,840.0	0.0	100.0
Бичиг хэрэг	14,040.3	24,296.4	-10,256.1	173.0
Тээвэр, шатахуун	16,599.6	16,532.3	67.3	99.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,200.1	30,057.7	11,142.4	73.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	953.6	-953.6	
Эд хогшил, урсгал засварын зардал	7,068.6	7,068.6	0.0	100.0
Багаж, техник, хэрэгсэл	1,346.4	961.0	385.4	71.4
Урсгал засвар	5,722.2	6,107.6	-385.4	106.7
Томиллолт, зочны зардал	20,033.3	20,033.3	0.0	100.0
Гадаад албан томиллолт	-	13,789.2	-13,789.2	
Дотоод албан томиллолт	20,033.3	6,244.1	13,789.2	31.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	135,429.7	134,994.0	435.7	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,151.2	128,003.0	148.2	99.9
Даатгалын үйлчилгээ	6,288.5	6,288.5	0.0	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	990.0	702.5	287.5	71.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	372,131.3	352,781.0	19,350.3	94.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	284,082.9	271,299.0	12,783.9	95.5
Засгийн газрын гадаад шилжүүлэг	284,082.9	271,299.0	12,783.9	95.5
Бусад урсгал шилжүүлэг	88,048.4	81,482.0	6,566.4	92.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,874.6	3,874.6	0.0	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,873.8	35,649.4	6,224.4	85.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,300.0	41,958.0	342.0	99.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,557,001.2	2,536,580.4	20,420.8	99.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,734,601.2	1,250,103.7	484,497.5	72.1
Улсын төсвөөс санхүүжих	1,734,601.2	1,250,103.7	484,497.5	72.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	822,400.0	1,286,476.7	-464,076.7	156.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	822,400.0	1,286,476.7	-464,076.7	156.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18.9	-	-